



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн
2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДГА-2026/01/НА-СТА-ТЭЗ

Цахим хуудас: www.audit.mn Дорноговь аймаг 2026 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 77520220 Аудитын менежер: Ахлах аудитор Аудитор:	Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn У.Оюунтүлхүүр Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn О.Нарангарав Цахим хаяг: narangarav.o@audit.gov.mn Н.Мөнхнасан Цахим хаяг: munkhnasan.n@audit.gov.mn
---	--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	9
3.2 Байгууллагын гадаад орчин	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	10
4. АУДИТЫН ТАЙЛАН	34
4.1 Ерөнхий зүйл.....	34
4.2 Материаллаг байдал	34
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	34
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	35
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	34
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	34
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	37
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	40

Товчилсон үгийн жагсаалт

ААН	Аж ахуйн нэгж
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АТБӨЯХ	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэл
ЗАА	Захирагчийн ажлын алба
ЗГБХН	Зарим гишүүд нь хариуцлагатай нөхөрлөл
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НААУ	Нийтийн аж ахуйн үйлчилгээ
НББ	Нягтлан бодох бүртгэл
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНӨ	Орон нутгийн өмчит
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨХХК	Орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СБТ	Санхүүгийн байдлын тайлан
СҮДТ	Санхүүгийн үр дүнгийн тайлан
ТАХ	Төсөл арга хэмжээ
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТӨЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ЭМГ	Эрүүл мэндийн газар



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн төсвийн 7 дугаар байр, Залуучуудын сууцанж,
7 дугаар багц, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103
Утас: (976) 7052 2734
Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2026.04.20 № 1-6/416

Тайлбар: _____ -ны № _____

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА О.БАТЖАРГАЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Дорноговь аймгийн аймгийн ТЕЗ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 481 дүгээр тогтоолоор "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, "Шинэ сэргэлтийн бодлого"-ын Хот хөдөөгийн сэргэлтийн зорилтыг хэрэгжүүлэх, хот хөдөөгийн хөгжлийн тэнцвэрийг хангах зорилгоор 2023-2028 оныг "Монголд зочлох жил" болгон зарласантай холбоотой аймгийн Засаг даргын 2025 оны А/01 захирамжаар Дорноговь аймаг 2025 оныг "Аялал жуулчлалыг дэмжих жил" болгон зарласан байна. Үүнтэй холбоотой тайлант оны 5 дугаар сард "Говийн бүсийн зөвлөгөөн", 9 дүгээр сард "Тэнгэрийн хутагт аялал жуулчлалын фестиваль"-ийг тус тус зохион байгуулсан байна.

Аудитын гол асуудал

1. Орон нутгийн төсвийн орлого 29.9 тэрбум төгрөгөөр тасарсан байна.
2. Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх зардлаас худалдан авсан 146.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг ашиглагч байгууллагын данс бүртгэлд тусгаагүй.

442505381

3. Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлсэн ТАХ-нд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

4. Орон нутагт үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудад дэмжлэг, санхүүжилт олгосон байна.

5. Ажил гүйлгээний анхан шатны баримтын бүрдэл дутуу, худалдан авсан болон гэрээгээр нийлүүлэгдэж байгаа бараа бүтээгдэхүүн хөрөнгийг хүлээж авсан, хүлээлгэн өгсөн акт, шийдвэр, бүртгэл, ажлын тайлан байхгүй, арга хэмжээг санхүүжүүлэхээр гарсан захирамжийн утга, огноонууд зөрүүтэй, тухайн арга хэмжээ нь зохион байгуулсан эсэх нь тодорхой бус, байгуулж байгаа гэрээний тоо хэмжээ хоорондоо зөрүүтэй гэх анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй.

Бусад асуудлын хэсэг

Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөгөөр 321 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр 138,002.3 сая төгрөгийн төсөв зарцуулахаар батлагдаж 99,649.1 сая төгрөгийг зарцуулан, үйл ажиллагааны хэрэгжилт 93.2 хувьтай дүгнэгдсэн байна.

АДБОУС 2706.10-д зааснаар хууль тогтоомжоор хориглоогүй, аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй, тухайлбал, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

№	Дансны нэр, төрөл	/мянган төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	72,040,599.8	87,015,725.9
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	34,025,648.2	30,555,446.5
3	1.1.3 АВЛАГА	6,976,599	7,464,667.4
4	1.1.4 УРЬДЧИЛГАА	4,289,762.3	1,457,224.3
5	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	9,618,322.3	10,339,138.9
6	1.1.6 НӨӨЦИЙН БАРАА	337,904	335,911.5
7	1.1.7 БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	16,792,364	36,863,337.3
8	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	195,865,967.8	229,718,399.5
9	1.2.1 УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	11,333,892.6	12,393,296.6
10	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	184,532,075.2	217,325,102.9
11	1.2.2.02 Биет хөрөнгө	177,091,460.1	210,198,092.3
12	1.2.2.03 Биет бус хөрөнгө	7,440,615.1	7,055,490.6
13	1.2.2.04 Бусад хөрөнгө /ТӨҮГ/	0.0	71,520
14	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	267,906,567.5	316,734,125.4
15	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР	79,080,557.3	118,065,085.6
16	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	29,168,690.7	66,986,535.0
17	2.1.1.03 Өглөг	27,904,938.8	62,140,532.0
18	2.1.1.04 Урьдчилж орсон орлого	1,263,751.9	4,846,003.0
19	2.1.2 УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	49,911,866.6	51,078,550.7
20	2.1.2.02 Урт хугацаат зээл	49,911,866.6	51,078,550.7
21	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	188,826,010.2	198,669,039.8
22	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо	188,826,010.2	198,669,039.8
23	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал	19,297,398	19,284,635.3
24	2.2.1.02 Өмч /төрийн/ /ТӨҮГ/	23,166,487.9	23,054,413.9
25	2.2.1.07 Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	523,470.7	594,990.7
26	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн	128,799,837.1	138,991,767.1
27	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	17,038,816.5	16,743,232.8
28	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	267,906,567.5	316,734,125.4

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

№	Дансны нэр, төрөл	/мянган төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	249,597,464.2	207,864,972.7
2	1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	108,739,825.4	105,945,819.8
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар	72,070,824.5	70,637,227.8
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар	54,229,038.3	62,715,119.8
5	1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-1,226,576.3	-1,571,918.7
6	1.1.1.03.1.04 ААН-ын орлогын албан татвар	19,068,362.5	9,494,026.7
7	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	8,195,282.3	10,424,347.9
8	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	28,473,718.6	24,884,244.1
9	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	133,194,594.2	101,919,152.9
10	1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	92,298,511.2	62,401,615.6
11	1.1.1.04.2 Хөрөнгийн орлого	43,875.0	17,291.0
12	1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	6,765,618.3
13	1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	40,852,208.0	32,734,628.0
14	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,663,044.7	0.0
15	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	174,652,331.1	175,138,114.4
16	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	174,652,331.1	175,137,463.8
17	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	163,670,255.1	159,089,128.3
18	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	27,462,818.4	32,257,270.4
19	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,391,944	4,184,994.4

20	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,968,682.8	14,566,192.2
21	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	57,551,277.3	54,956,201.4
22	1.1.2.01.1.05 Нормативт зардал	517,195.6	1,013,145
23	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	1,501,697.3	1,590,493.1
24	1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	345,371.5	309,833.9
25	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	41,031,397.3	22,659,438.5
26	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	18,899,870.9	27,551,559.5
27	1.1.2.01.2 ХҮҮ	0.0	0.9
28	1.1.2.01.3 ТАТААС	0.0	4417144353 2,146
29	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,982,076	16,046,188.6
30	1.1.2.02 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	650.5
31	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	74,945,133.1	32,726,858.4
32	1.2.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.0	57,958.7
33	1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	11,693,743.9	22,968,835.1
34	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	-11,693,743.9	-22,910,876.4
35	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	63,251,389.3	9,815,981.9

2.3 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	125,302,909.7	125,302,909.7
2	1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-352,068.1	-352,068.1
3	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	124,950,841.6	124,950,841.6
4	1.1.1.1.2 Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-60,507.1	-60,507.1
5	1.1.1.1.3 Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	18,300	18,300
6	1.1.1.1.5 Өмчид гарсан өөрчлөлт	665,986.5	665,986.5
7	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	63,251,389.3	63,251,389.3
8	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	188,826,010.2	188,826,010.2
9	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	188,826,010.2	188,826,010.2
10	1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-326,651.5	-326,651.5
11	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	188,499,358.7	188,499,358.7
12	1.2 Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	75,374	75,374
13	1.3 Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-212,552.6	-212,552.6
14	1.4 Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	3,357.6	3,357.6
15	1.5 Өмчид гарсан өөрчлөлт	487,520.1	487,520.1
16	1.7 Тайлант үеийн үр дүн	9,815,981.9	9,815,981.9
17	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	198,669,039.7	198,669,039.8

2.4 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	204,530,709.3	184,815,773.1
2	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	108,735,796.1	105,945,819.8
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	72,020,421	70,637,227.8
4	1.1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар	54,178,634.9	62,715,119.8
5	1.1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-1,226,576.3	-1,571,918.7
6	1.1.1.1.03.1.04 ААН-ын орлогын албан татвар	19,068,362.5	9,494,026.7
7	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	8,241,656.5	10,424,347.9
8	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	28,473,718.6	24,884,244.1
9	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	17,167,845.4	14,295,075.3
10	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	8,426,114.8	8,751,271.4

10	1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	2,879,758.4	1,837,897.4
11	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	86,740,889.9	78,869,953.3
12	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	45,844,806.9	35,220,084.6
13	1.1.1.1.04.2 Хөрөнгийн орлого	43,875	17,291.0
14	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	10,897,949.7
15	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	40,852,208	32,734,628.0
16	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	9,054,023.3	0.0
17	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	160,814,820.3	159,223,962.9
18	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	160,814,820.3	159,223,962.9
19	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	118,827,640.2	121,082,768.9
20	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	34,699,387.2	41,707,422.6
21	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,507,494.3	4,258,124.4
22	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,078,304.6	17,277,342.3
23	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	9,666,623.6	11,974,007
24	1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	449,306.1	374,961.3
25	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	1,549,395.3	1,636,867.4
26	1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	351,691.3	296,411.7
27	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	40,635,165.1	28,280,672.8
28	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	10,890,272.6	15,276,959.4
29	1.1.1.2.01.3 ТАТААС	200,000	2,146.0
30	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	41,787,180.1	38,139,048.0
31	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	43,715,889	25,591,810.2
32	1.1.2.1 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,918,627.5	6,424,296.7
33	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	30,572,204.5	35,482,481.9
34	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	30,572,204.5	35,482,481.9
35	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	30,572,204.5	35,482,481.9
36	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-28,653,577	-29,058,185.1
37	1.1.3.1 Бусад эх үүсвэр	9,800	0.0
38	1.1.3.4 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	68,014.5	3,826.8
39	1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-58,214.5	-3,826.8
40	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	15,004,097.4	-3,470,201.7
41	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	19,021,550.8	34,025,648.2
42	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	34,025,648.2	30,555,446.5

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	179,365,151.3	148,999,943.0
2	3.1.01.1.1 Татварын орлого	134,165,164	105,945,819.8
3	3.1.01.1.1.1 Орлогын албан татвар	72,040,114.1	70,637,227.8
4	3.1.01.1.1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	57,703,227.2	62,715,119.8
5	3.1.01.1.1.1.1.01 Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	47,274,879.4	53,590,350.8
6	3.1.01.1.1.1.1.02 Үйл ажиллагааны орлого	3,453,000	3,479,689.6
7	3.1.01.1.1.1.1.03 Хөрөнгийн орлого	3,563,100	2,409,648.5
8	3.1.01.1.1.1.1.04 Хөрөнгө борлуулсны орлого	1,253,000	1,121,673.6
9	3.1.01.1.1.1.1.07 Шууд бус орлого	2,159,247.8	2,113,757.2

10	3.1.01.1.1.1.2 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-1,571,918.7	-1,571,918.7
11	3.1.01.1.1.1.2.01 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-1,571,918.7	-1,571,918.7
12	3.1.01.1.1.1.4 ААН-ын орлогын албан татвар	15,908,805.6	9,494,026.7
13	3.1.01.1.1.1.4.01 ААН-ын орлогын албан татвар	15,908,805.6	9,494,026.7
14	3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар	10,768,696	10,424,347.9
15	3.1.01.1.1.3.1 Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	8,542,569	8,396,401.6
16	3.1.01.1.1.3.2 Бууны албан татвар	30,315	30,151.5
17	3.1.01.1.1.3.3 Автомтээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	1,764,000	1,687,949
18	3.1.01.1.1.3.4 Малд ногдуулах албан татвар	431,812	309,845.8
19	3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж	51,356,353.9	24,884,244.1
20	3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	18,243,901.6	14,295,075.3
21	3.1.01.1.1.8.1.01 Улсын тэмдэгтийн хураамж	16,954,672	13,174,694.5
22	3.1.01.1.1.8.1.06 Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	709,412	512,026.8
23	3.1.01.1.1.8.1.08 Хог хаягдлын үйлчилгээний хураамж	579,817.6	608,354
24	3.1.01.1.1.8.2 Газрын төлбөр	31,596,000.3	8,751,271.4
25	3.1.01.1.1.8.2.01 Газрын төлбөр	5,796,000.3	4,273,585.7
26	3.1.01.1.1.8.2.02 Дуудлага худалдаа	25,800,000	4,477,685.7
27	3.1.01.1.1.8.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр	1,516,452	1,837,897.4
28	3.1.01.1.1.8.3.02 Ан амьтны нөөц ашигласны төлбөр	436,452	491,261
29	3.1.01.1.1.8.3.03 Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	1,080,000	1,346,636.4
30	3.1.01.1.2 Татварын бус орлого	45,199,987.3	43,054,123.1
31	3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого	11,817,782.7	10,302,204.1
32	3.1.01.1.2.1.2 Хүүгийн орлого	506,047.2	0.0
33	3.1.01.1.2.1.3 Торгуулийн орлого	6,419,184.9	6,118,396.7
34	3.1.01.1.2.1.4 Төсөв байгууллагын өөрийн орлого / үндсэн/	790,675.5	1,050,817.2
35	3.1.01.1.2.1.5 Төсөв байгууллагын өөрийн орлого / туслах/	461,575.5	560,618.2
36	3.1.01.1.2.1.6 Түрээсийн орлого	60,000	152,611.3
37	3.1.01.1.2.1.9 Бусад орлого	3,580,299.6	2,419,760.8
38	3.1.01.1.2.2 Хөрөнгийн орлого	20,000	17,291
39	3.1.01.1.2.2.1 Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	20,000	17,291
40	3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	33,362,204.6	32,734,628
41	3.1.01.1.2.4.2 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	33,362,204.6	32,734,628
42	3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	188,966,926.4	140,023,149.4
43	3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	138,509,720.5	108,341,607.9
44	3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	85,567,004.5	74,063,750.8
45	3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	31,791,479.7	30,844,201.6
46	3.1.01.2.1.1.1.01 Үндсэн цалин	13,084,756.9	12,975,228
47	3.1.01.2.1.1.1.02 Нэмэгдэл	13,368,591.8	12,917,904.9
48	3.1.01.2.1.1.1.03 Унаа хоолны хөнгөлөлт	2,051,961.3	2,010,492.9
49	3.1.01.2.1.1.1.04 Урамшуулал	1,783,987.7	1,495,041
50	3.1.01.2.1.1.1.05 Гэрээт ажлын хөлс	1,502,182	1,445,534.8
51	3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,046,857.8	3,762,479.2
52	3.1.01.2.1.1.2.01 Тэтгэврийн даатгал	2,720,144.5	2,560,712.4
53	3.1.01.2.1.1.2.02 Тэтгэмжийн даатгал	329,335.2	324,314.7
54	3.1.01.2.1.1.2.03 ҮОМШӨ-ний даатгал	186,274.6	168,217.8
55	3.1.01.2.1.1.2.04 Ажилгүйдлийн даатгал	147,980	128,618.5
56	3.1.01.2.1.1.2.05 Эрүүл мэндийн даатгал	663,123.5	580,615.7
57	3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,337,249.1	14,510,018
58	3.1.01.2.1.1.3.01 Гэрэл, цахилгаан	2,012,110.1	1,716,159.3
59	3.1.01.2.1.1.3.02 Түлш, халаалт	11,944,003.9	11,538,862.9
60	3.1.01.2.1.1.3.03 Цэвэр, бохир ус	1,259,553.4	1,109,656

61	3.1.01.2.1.1.3.04 Байрны түрээс	121,581.7	145,339.8
62	3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	1,608,723.7	1,312,803.2
63	3.1.01.2.1.1.4.01 Бичиг хэрэг	168,669.9	120,143.3
64	3.1.01.2.1.1.4.02 Тээвэр, шатахуун	867,257.3	799,707
65	3.1.01.2.1.1.4.03 Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	202,065.7	147,383.4
66	3.1.01.2.1.1.4.04 Ном, хэвлэл	3,000	1,430
67	3.1.01.2.1.1.4.05 Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	173,204	163,519.7
68	3.1.01.2.1.1.4.06 Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	194,526.8	121,619.7
69	3.1.01.2.1.1.5 Нормативт зардал	480,200.7	326,145
70	3.1.01.2.1.1.5.01 Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	389,124.9	250,385.3
71	3.1.01.2.1.1.5.03 Нормын хувцас, зөөлөн эдлэл	91,075.8	75,759.6
72	3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	2,070,178.5	1,804,214.6
73	3.1.01.2.1.1.6.01 Багаж, техник, хэрэгсэл	433,779.9	352,641.8
74	3.1.01.2.1.1.6.02 Тавилга	31,130	19,190
75	3.1.01.2.1.1.6.03 Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	20,000	17,477.9
76	3.1.01.2.1.1.6.04 Урсгал засвар	1,585,268.6	1,414,904.9
77	3.1.01.2.1.1.7 Томилолт, зочны зардал	336,714.2	256,771.8
78	3.1.01.2.1.1.7.02 Дотоод албан томилолт	294,914.2	219,707.6
79	3.1.01.2.1.1.7.03 Зочин төлөөлөгч хүлээн авах	41,800	37,064.2
80	3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,614,706.4	15,955,900.4
81	3.1.01.2.1.1.8.01 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,492,915.5	15,893,897.4
82	3.1.01.2.1.1.8.02 Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	14,534.5	4,164
83	3.1.01.2.1.1.8.03 Даатгалын үйлчилгээ	27,666.3	20,067.2
84	3.1.01.2.1.1.8.04 Тээврийн хэрэгслийн татвар	15,019.7	6,169.1
85	3.1.01.2.1.1.8.05 Тээврийн хэрэгслийн оношлогоо	8,227.4	4,747.8
86	3.1.01.2.1.1.8.06 Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,982.8	480.1
87	3.1.01.2.1.1.8.07 Газрын төлбөр	47,360.2	26,375
88	3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	8,280,894.4	5,290,217
89	3.1.01.2.1.1.9.01 Бараа үйлчилгээний бусад зардал	8,157,798.6	5,212,563.7
90	3.1.01.2.1.1.9.02 Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	123,095.8	77,653.4
91	3.1.01.2.1.3 ТАТААС	200,000	0.0
92	3.1.01.2.1.3.2 Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	200,000	0.0
93	3.1.01.2.1.3.2.01 Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	200,000	0.0
94	3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	52,742,716	34,277,857.2
95	3.1.01.2.1.4.1 Засгийн газрын урсгал шилжүүлэг	50,948,071.2	33,375,332.1
96	3.1.01.2.1.4.1.01 Засгийн газрын дотоод шилжүүлэг	50,948,071.2	33,375,332.1
97	3.1.01.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	1,794,644.8	902,525.1
98	3.1.01.2.1.4.2.02 Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	146,400	80,790
99	3.1.01.2.1.4.2.04 Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	964,454.4	368,803.4
100	3.1.01.2.1.4.2.06 Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	196,587.2	179,967.9
101	3.1.01.2.1.4.2.07 Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	297,867.5	163,695
102	3.1.01.2.1.4.2.08 Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	189,335.7	109,268.8
103	3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	49,951,158.5	31,681,541.5
104	3.1.01.2.2.2 Их засвар	3,389,669.8	2,177,068.8
105	3.1.01.2.2.4 Бусад хөрөнгө	46,561,488.7	29,504,472.6
106	3.1.01.2.3 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	506,047.4	0.0
107	3.1.01.2.3.1 Эргэж төлөгдөх зээл	506,047.4	0.0
108	3.1.01 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-9,601,775.1	8,976,793.6
109	3.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	9,601,775.1	-8,976,793.6

110	3 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	9,601,775.1	-8,976,793.6
111	4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	11,666,405.3
112	5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	20,677,133.5

2.5 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

4417144353
/миллион төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	10,348,804.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,348,804.2
350011	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,569.1
350013	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	315,000.0
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,279,420.3
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,752,814.9
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,332,304.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,332,304.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,325,234.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	9,878.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	118.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,842.5
2104	Хангамж, бараа материалын зардал	165,773.6
2105	Норматив зардал	9,402.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	67,365.9
2107	Томилолт, зочны зардал	17,240.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,175,221.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	872,391.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,070.0
3	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-1,016,500.3
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	500.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	500.0

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Дорноговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 40 төсвийн байгууллага, 14 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 30 тусгай сан, 14 төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайлан, нийт 98 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 98 байгууллага аудитад хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас 48 байгууллагыг түүвэрт хамруулж, 50 байгууллагад дүгнэлт гаргаж “Өөрчлөлтгүй” 36, “Өөрчлөлттэй” 13, “Сөрөг” 1 дүгнэлтийг хүргүүлсэн байна.

ТЕЗ-ийн харьяа байгууллагуудад санхүүгийн тайлангийн аудитаар нийт 96,759.2 сая төгрөгийн 358 алдаа, зөрчил илрүүлснээс 93,053.6 сая төгрөгийн 213 алдааг залруулж, 102.6 сая төгрөгийн зөрчилд 22 төлбөрийн акт тогтоож, 1,443.2 сая төгрөгийн зөрчилд 68 албан шаардлага, 2,159.7 сая төгрөгийн зөрчилд 49 зөвлөмж, хариуцлага тооцуулах 6 албан шаардлага хүргүүлсэн.

Төсвийн ерөнхийлөн захирагч болон түүний харьяа байгууллагууд, төсөв захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 4,175.8 сая төгрөгийн 150 зөрчил илэрснээс нийцлийн аудиттай холбоотой 2,035.4 сая төгрөгийн зөрчлийг хасаж санхүүгийн тайлангийн аудитад хамаарах 2,140.4 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшингөөс бага байх тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгөв

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар

Аудитаар нийт 4,206.1 сая төгрөгийн 18 алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 4,206.1 сая төгрөгийн 13 алдааг залруулж, 1 албан шаардлага, 4 зөвлөмжийг хүргүүлсэн байна. 11 төсвийн төвлөрүүлэн захирагчид өөрчлөлтгүй дүгнэлт, 3 өөрчлөлттэй дүгнэлт өгсөн байна.

Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа төсвийн шууд захирагчийн 40 байгууллагаас 15 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 25 дүгнэлт өгсөн байна. Үүнээс: өөрчлөлтгүй 16, өөрчлөлттэй 9 дүгнэлтийг хүргүүлсэн байна.

Аудитаар нийт 26,621.6 сая төгрөгийн 211 алдаа, зөрчил илрүүлснээс 25,913.7 сая төгрөгийн 115 алдааг залруулж, 71.6 сая төгрөгийн зөрчилд 17 төлбөрийн акт тогтоож, 539.5 сая төгрөгийн зөрчилд 47 албан шаардлага, 96.7 сая төгрөгийн зөрчилд 31 зөвлөмж, хариуцлага тооцуулах 1 албан шаардлага хүргүүлсэн.

Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа орон нутгийн өмчит 14 аж ахуйн нэгж байгууллагаас 3 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 11 байгууллагад дүгнэлт өгсөн байна. Үүнээс “Өөрчлөлтгүй” 9, “Өөрчлөлттэй” 1, “Сөрөг” 1 дүгнэлтийг хүргүүлсэн байна.

Аудитаар нийт 2,514.6 сая төгрөгийн 42 алдаа, зөрчил илрүүлснээс 2,054.9 сая төгрөгийн 13 алдааг залруулж, 29.9 сая төгрөгийн 4 төлбөрийн акт, 377.7 сая төгрөгийн зөрчилд 7 албан шаардлага, 52.0 сая төгрөгийн зөрчилд 13 зөвлөмж, хариуцлага тооцуулах 5 албан шаардлага хүргүүлсэн.

Тусгай санд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа 30 сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан байна.

Аудитаар нийт 63,416.9 сая төгрөгийн 87 алдаа, зөрчил илрүүлснээс 60,878.9 сая төгрөгийн 72 алдааг залруулж, 1.1 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 525.9 сая төгрөгийн зөрчилд 13 албан шаардлага, 2,011.0 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар

Аудитаар нийт 1,266.4 сая төгрөгийн 1 алдаа илэрснээс аудитын явцад залруулсан. Үүнд:

Санхүүгийн нэгтгэсэн тайланд 2 сумын аудиталсан тайланг зөрүүтэй тайлагнаснаас, мөн Засаг даргын тайланд түншлэл-хөгжлийн зээлийн эргэн төлөлтийг буруу бүртгэснээс нэгтгэл тайланг нийт 1.266.4 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

Аудитаар нийт 470.3 сая төгрөгийн 5 зөрчил илрүүлж, 346.1 сая төгрөгийн 2 албан шаардлага, 124.1 сая төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

5.1 Албан шаардлага

1. Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх зардлаас худалдан авсан 146.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг ашиглагч байгууллагын данс бүртгэлд тусгаагүй.

2. Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлсэн 199.8 сая төгрөгийн ТАХ-нд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

5.2 Зөвлөмж

1. Илрүүлэлт: Аймгийн орон нутгийн төсвийн орлогыг 145,064.3 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 115,175.6 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэн, орлогын биелэлт 29,888.7 сая төгрөгөөр тасарч, төлөвлөгөө 79.4 хувиар хэрэгжсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д бүх шатны төсөв захирагч "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" үүрэгтэй гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг тооцоолол судалгаанд үндэслэн боловсруулж, биелэлтийг бүрэн хангаж ажиллах

2. Илрүүлэлт: Орон нутагт үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудад нийт 24.9 сая төгрөгийн дэмжлэг, санхүүжилт олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.5-д "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль болон энэ хуульд заасан шаардлагыг хангаагүй төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх, төсвөөс санхүүжүүлэхийг хориглоно", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4-т "Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэхийг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн хөрөнгөөр төрийн бус байгууллагад дэмжлэг, санхүүжилт олгохгүй байх, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.4 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах

3. Илрүүлэлт: Ажил гүйлгээний анхан шатны баримтын бүрдэл дутуу, худалдан авсан болон гэрээгээр нийлүүлэгдэж байгаа бараа бүтээгдэхүүн хөрөнгийг хүлээж авсан, хүлээлгэн өгсөн акт, шийдвэр, бүртгэл, ажлын тайлан байхгүй, арга хэмжээг санхүүжүүлэхээр гарсан захирамжийн утга, огноонууд зөрүүтэй, тухайн арга хэмжээ нь зохион байгуулсан эсэх нь тодохой бус, байгуулж байгаа гэрээний тоо хэмжээ хоорондоо зөрүүтэй гэх анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.6 "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.5 "Ерөнхий нягтлан бодогч дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах үүрэгтэй" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Зарцуулах шийдвэр, худалдан худалдан авах гэрээний тоо хэмжээ, хугацаа, мөнгөн дүнг хянан баталгаажуулах, төлбөр тооцоог хүчин төгөлдөр анхан шатны баримтад үндэслэн хийж гүйцэтгэх, бараа материал, хөрөнгийг орлого, зарлагын баримт хөтлөх, тайлан гаргах, хүлээлцсэн акт үйлдэх, анхан шатны баримтын бүрдлийг ханган ажиллах.

Дээрх зөвлөмжийн хэрэгжилтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн дотор Төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.